



**МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII байр,
Утас: 26-36-95, Факс: (976-11) 32-35-41
И-мэйл: letter@moh.gov.mn, <http://moh.gov.mn>

2025. 12. 19 № 1/6062
танай _____-ны № _____-т

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН Ц.БААТАРХҮҮ ТАНАА**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалтад заасан гишүүний бүрэн эрхийн дагуу танаас ирүүлсэн эрүүл мэндийн салбарын санхүүжилт, анхан шатны тусламж, үйлчилгээний хүртээмж, лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагын ачаалал, үнэлгээ, эрүүл мэндийн даатгалын сангийн зарцуулалттай холбоотой асуулгын хариуг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт/0 хуудас.

Хүндэтгэсэн,



Ж.ЧИНБҮРЭН

141250618

Эрүүл мэндийн салбарын санхүүжилт болон бусад холбогдох асуудлын талаар Монгол Улсын Их Хурлын гишүүний асуулгын хариу

1. Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын үед улсын төсвөөс зарцуулсан нийт хөрөнгийн хэмжээ, үүнээс вакцинжуулалт, тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгсэл, оношилгоо зэрэгт хэдэн хувийг зарцуулсан;
 - Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын үед буюу 2020-2022 онд улсын төсвөөс нийт 501.6 тэрбум төгрөг (2020 онд 68.8 тэрбум, 2021 онд 148.8 тэрбум төгрөг, 2022 онд 284.0 тэрбум төгрөг) зарцуулсан байна. Тус зарцуулалтыг задалбал эм, урвалж оношлуурт 58.8 (11.7%) тэрбум төгрөг, эм, эмнэлгийн мэргэжилтэний илүү цаг, урамшуулалд 56.2 (11.2%) тэрбум, нэг удаагийн хамгалах хувцас хэрэгсэл, бараа материалд 48.0 (9.6%) тэрбум, эмнэлгийн тусламж, үйлчилгээ, нийгмийн эрүүл мэндийн хариу арга хэмжээнд 324.0 (64.6%) тэрбум, тоног төхөөрөмж, хөрөнгө оруулалтын зардалд 14.7 (2.9%) тэрбум төгрөг зарцуулсан байна.
2. Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын үед 500 орчим тэрбум төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас гаргасан нь санхүүгийн эрсдэл үүсгэсэн эсэх, тус зардлыг буцаан санд төлж дууссан эсэх болон Засгийн газраас Эрүүл мэндийн даатгалын сангийн төлбөрийн үүргийг дахин тогтоох, тодорхой болгох асуудлаар хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бодлого, арга, хэмжээ;
 - Коронавируст халдварт (Ковид-19)-ын цар тахлын үед Эрүүл мэндийн даатгалын сангийн эх үүсвэрээр 322.9 тэрбум төгрөг, бусад эх үүсвэрээс тус сангаар дамжуулан 357.5 тэрбум төгрөг нийт 680.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг зарцуулсан байна. Эрүүл мэндийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс зарцуулсан санхүүжилтийг буцаан төвлөрүүлээгүй байна. Тус зарцуулалтыг задалбал дархлаажуулалтын үйл ажиллагаанд 27.1 тэрбум төгрөг, өрхийн гэрийн хяналтад 95.0 тэрбум төгрөг, ПГУ сорил цуглуулах үйл ажиллагаанд 4.0 тэрбум төгрөг, PCR шинжилгээнд 44.4 тэрбум төгрөг, эмнэлгийн хэвтэн эмчлүүлэх тусламж, үйлчилгээнд 509.9 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан байна.
 - Монгол Улсын эрүүл мэндийн даатгалын тогтолцоог бэхжүүлэх, үйл ажиллагааг сайжруулах 2026-2028 оны арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан, холбогдох байгууллагуудаас саналыг авч тусган, 2025 оны 12 дугаар сард багтаан батлуулахаар ажиллаж байна. Тус арга хэмжээний төлөвлөгөөнд “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцуудад нарийвчилсан судалгаа хийж, эмнэлзүйн хувьд технологи нь хоцрогдсон үр дүн муутай, зардал ихтэй эмчилгээ, үйлчилгээг хасах, төлбөртэй тусламж, үйлчилгээ болон хамтын төлбөрийн талаар судалгаа хийж, иргэдийг санхүүгийн эрсдэлд оруулахгүй түвшинд холбогдох өөрчлөлтийг хийж, хэрэгжүүлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эмнэлзүйн, дэмжих болон санхүүгийн үйл ажиллагааг нэгтгэж тусламж, үйлчилгээний өртөг тооцох үйл ажиллагааг институтчилэх” зэрэг Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийн тогтолцоог сайжруулах арга хэмжээг төлөвлөөд байна.
 - Мөн “Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулга”-г 2026 оны эхний улиралд багтаан өргөн мэдүүлэхээр Улсын Их Хурлын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны 2025 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 03 дугаар тогтоолоор Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн биелэлтэд хяналт шалгалт хийж, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл

боловсруулах ажлыг хэсгийг байгуулан ажиллаж байгаа бөгөөд Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/428 тушаалаар дэд ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Тус ажлын хэсгүүд нь даатгалын хуулийн хэрэгжилт, засаглал, тогтолцоо, стратегийн худалдан авалтын тогтолцооны хэрэгжилт, сангийн зарцуулалт, хуулийн хэрэгжилтийн үр дагавар, бусад хуулиудын уялдаа холбоо, олон улсын сайн туршлага судлах зэрэг ажлыг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

3. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх болон гарсан үед авах хариу арга хэмжээ, эмнэлгийн тусламж, үйлчилгээний зардлыг зөвхөн Засгийн газрын нөөцөөс бүрэн санхүүжүүлэх боломж, шаардлагатай тохиолдолд нэмэлт санхүүжилтийн эх үүсвэр байгаа эсэх;

- Засгийн газрын нөөц сан нь тухайн жилийн төсөвт урьдчилан тооцож, төлөвлөн тусгах боломжгүй, хойшлуулшгүй цаг үеийн шинжтэй арга хэмжээ болон Гамшгаас хамгаалах тухай хуульд заасан гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгийн хор уршгийг арилгах үйл ажиллагааг шат дараатай зохион байгуулах зорилгоор улс, орон нутгийн төсвийн гамшгаас хамгаалах арга хэмжээний зардлын хүрэлцэхгүй хэсгийг санхүүжүүлэх зориулалттай байдаг. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 11 дүгээр зүйл 11.5 дахь хэсэгт Засгийн газрын нөөц сангийн хөрөнгөөр санхүүжих арга хэмжээг баталсан байна. Мөн сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журмыг Засгийн газар батлахаар хуульчилсан ба үүнийг дагуу Засгийн газрын 2021 оны “Журам батлах тухай” 51 дүгээр тогтоолын хавсралтаар сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам батлагдан, хэрэгжиж байна. Дээрх хууль журамд зааснаар халдварт өвчин гарсан үед гамшгийн эрсдэлийг үнэлэх, болзошгүй хохирлын хэмжээг багасгах, гамшгийг хохирол багатай даван туулах чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээ авах болон гамшиг, аюулын улмаас хүний амь нас, эрүүл мэнд хохирсон зэрэг сөрөг үр дагаврыг зогсоох, бууруулах, хохирол багатай давахад чиглэсэн хойшлуулшгүй арга хэмжээ авах зардлыг Засгийн газрын нөөц сангаас хариуцахаар хуульчлагдсан.
- 2025 онд дээрх хууль, журмын дагуу Монгол Улсын Засгийн газрын 08 дугаар тогтоолоор улаанбурхан өвчний тархалтыг хязгаарлах, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээ авахад Засгийн газрын нөөц сангаас 5.0 тэрбум төгрөг, 179 дүгээр тогтоолоор томуу, томуу төст өвчин, амьсгалын замын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 1.4 тэрбум төгрөгийг олгоод байна.

4. Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсөвт төвлөрүүлэх орлого 2,515.0 тэрбум төгрөг, зарлага 2,135.0 тэрбум төгрөг, сангийн нийт зардал (эмчилгээ, эмийн хөнгөлөлт, урсгал зардал, хөрөнгө оруулалт гэх мэт) хэдэн хувиар өссөн, 2022-2023 оны хуримтлагдсан өр 218.0 тэрбум төгрөг. Энэ өрийг 2025 онд хэрхэн төлөх талаар болон алдагдлыг бууруулах бодлогын хүрээнд шимтгэлийн хэмжээг 2 хувиар нэмэгдүүлснээр гарах үр дүнгийн талаарх тооцоолол бүхий судалгаа;

- Сангийн тэнцэл алдагдаж, хуримтлагдсан өр төлбөр нэмэгдэж байгаа учраас тэнцлийг хангах үүднээс тусламж, үйлчилгээг эрэмбэлэх, давхардлыг нь арилгах, үр ашгийг сайжруулах бодлогын өөрчлөлтүүд, нэн шаардлагатай бус, эмнэлзүйн үр дүн багатай тусламж, үйлчилгээний тоо хэмжээг хязгаарлах, давхардлыг нь арилгах зэрэг арга хэмжээнүүдийг авч байна.
- 2025 оны Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн тухай хуулиар батлагдсан төсвийн хүрээнд өмнөх жилүүдэд хуримтлагдсан нийт өр төлбөр болох 316.0 тэрбум төгрөгийг 2025 оны эхний улиралд бүрэн барагдуулсан бөгөөд үлдэж буй санхүүжилтэд хамгийн оновчтой, үр дүнтэй, даатгуулагчийн амь нас аврах чиглэлийн тусламж, үйлчилгээнд зарцуулж, тэнцлийг хангах бодлогыг баримталж ажиллаж байна.

- Ажил олгогч, даатгуулагчаас төлөх шимтгэлийн орлогыг 2025 онд өмнөх оноос 281.6 тэрбум төгрөгөөр нэмэгдүүл баталсан нь биелэх боломжгүй төлөвлөгөө болсон ба оны эцсийн хүлээгдэж буй гүйцэтгэлээр эрүүл мэндийн даатгалын сангийн нийт орлого 207.0 орчим тэрбум төгрөг тасрахаар байна. Иймд санхүүгийн хатуу сахилга бат доор зардлуудыг эрэмбэлэх, хязгаарлах, хойшлуулах, өөр хямд эмчилгээний аргуудыг хэрэглэх зэргээр ажиллаж байна. Үүний үр дүн 2026 оноос хуримтлагдсан өр төлбөр байхгүй, сангийн тэнцлийг хангаж, эрүүл мэндийн байгууллагуудад цаг тухайд нь төлбөр тооцоо гүйцэтгэх боломж бий болно гэж үзсэн.
 - Шитгэлийг нь төр хариуцах иргэдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд ЭМД-ын сангийн нийт зардлын 80 орчим хувийг зарцуулж байгаа ч тэдний шимтгэлийн орлого нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдаатай ба ЭМД-ын сангийн шимтгэлийн орлогын ердөө 20 орчим хувийг эзэлж байна. Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт төр хариуцах иргэдийн шимтгэлийн хувь хэмжээг 3 хувь хүргэх зорилтыг тавьсан. Үүний дагуу 2026 оны төсвийн төсөлд тус шимтгэлийн хувь хэмжээг 3 хувь байхаар тооцоход 300.2 тэрбум төгрөгөөр сангийн орлого 2025 оны батлагдсан төсвөөс нэмэгдэхээр санал хүргүүлсэн ч Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд тус шимтгэлийн хувь хэмжээ нэмэгдэж батлагдаагүй.
5. 2021 оноос хэрэгжүүлсэн гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн тогтолцоо хэрэгжиж эхэлснээс хойш эрүүл мэндийн байгууллагууд хүндрэлтэй ажиллаж байна. Тогтолцоог сайжруулах талаар авч байгаа арга хэмжээ, эрүүл мэндийн байгууллагуудыг сонгон шалгаруулах, төлбөр, чанарын шалгуурын журмууд 2022 оноос шинэчлэгдээгүй байгаа нь сангийн тэнцэлд доголдол, алдагдал үүсэхэд нөлөөлсөн эсэх;
- 2021 оноос гүйцэтгэлийн санхүүжилтэд шилжсэнээр эрүүл мэндийн байгууллагуудын санхүүжилт жил бүр нэмэгдсэн байна. Тухайлбал лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагын гүйцэтгэл 2022 онд 1,032.9 тэрбум төгрөг, 2023 онд 1,261.0 тэрбум төгрөг, 2024 онд 1,423.0 тэрбум төгрөг болсон бөгөөд 2025 оны хүлээгдэж гүйцэтгэлээр архаг тусламж, үйлчилгээг хязгаарласны үр дүнд 1,363.5 тэрбум төгрөг болохоор байна.
 - ЭМДҮЗ-ийн 2022 оны “Нэхэмжлэлийн хяналтын нарийвчилсан шалгуур батлах тухай” 12 дугаар тогтоол шинэчлэгдээгүйтэй холбоотойгоор жил бүр нэхэмжлэлийн хяналтын хасагдлын хувь буурч байна.
 - ЭМДҮЗ-ийн 2022 оны 02 дугаар тогтоолоор нэгдсэн сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасны дагуу 3 жилийн хугацаатай “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ худалдан авах гэрээ” байгуулсан бөгөөд 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрөөр гэрээний хугацаа дуусгавар болсон. Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/388 тушаалаар эрүүл мэндийн даатгалын сангаас тусламж, үйлчилгээ худалдан авах эрүүл мэндийн байгууллага сонгон шалгаруулах журамд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээний үлгэрчилсэн загварыг шинэчлэн боловсруулж батлуулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Тус ажлын хэсэг “Нэгдсэн сонгон шалгаруулалтын журам”-ын шинэчилсэн төлсийг боловсруулан, өргөтгөсөн ажлын хэсгээр хэлэлцүүлсэн ба ЭМДҮЗ-ийн хуралдаанд танилцуулж, 2025 оны 12 дугаар сард багтаан батлуулахаар бэлтгэл ажил хангагдаад байна.
6. Эрүүл мэндийн даатгалын санхүүжилт 2-3 сараар хоцорч байгаа шалтгаан;
- Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийг төсвийн сар улирлын хуваарьт багтаан гэрээнд заасан төсвийн дагуу 2025 оны 8 сарыг хүртэл бүрэн олгосон. Гэвч даатгалын сангийн 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр үүсэх өр төлбөрийг бууруулах болон сангийн төсвийн үр ашгийг дээшлүүлэх зорилгоор төр, хувийн хэвшлийн бүх эрүүл мэндийн байгууллагад олгох эрүүл мэндийн

тусламж, үйлчилгээний санхүүжилтийг 2025 оны тоо хэмжээтэй уялдуулан олгохоор тодорхой ажлыг зохион байгуулж 9 дүгээр сараас төсвийн нарийвчилсан хуваарийг өөрчлөх шаардлага үүссэний дагуу зарим эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагуудын санхүүжилт тодорхой хугацаанд хоцорч орсон.

7. Дээрх гүйцэтгэлд суурилсан санхүүжилттэй холбоотойгоор Эрүүл мэндийн төвүүдийн 2025 оны ачаалал, бодит байдалд үүссэн хүндрэл, нөхцөл байдал, нэг иргэнээр тооцсон санхүүжилт анхан шатны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд дэмжлэг болж чадсан эсэх;

- Анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд нь жил бүр харьяалах хүн амынхаа эрүүл мэндийн байдлыг тогтсон асуумж, үйлдлээр үнэлэх, халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлэгийг тухайн өвчнийг илрүүлж болох тогтсон наснуудад хийх, шаардлагатай бол дараагийн шатлалд шилжүүлэх, өөрсдийн хянаж чадах ХБӨ-ий тохиолдлууд болон жирэмсэн, нярай, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хянах, товлот болон нэмэлт дархлаажуулалт хийх, асрах, сувилах сэргээн засах, эмчлэх (ӨЭМТ-д өдрөөр, СЭМТ-д өдрөөр болон хэвтүүлэн) хөнгөвчлөх, яаралтай, түргэн тусламжийг үзүүлэх юм. ЭМС-ын баталсан анхан шатны тусламж, үйлчилгээний багцаас оношилгоо шинжилгээ, өдрийн эмчилгээ, гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ, зарим сэргээн засах тусламж, үйлчилгээг ЭМДС-аас тохиолдолд суурилсан төлбөрийн аргаар санхүүжүүлдэг. Ийнхүү санхүүжүүлэхдээ өдрийн эмчилгээ, гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ, сэргээн засах тусламж, үйлчилгээг ЭМС-ын баталсан оношийн хүрээнд холбогдох журмын дагуу санхүүжүүлдэг. Харин оношилгоо шинжилгээний хувьд яг ямар оношилгоо шинжилгээг ЭМДС-аас санхүүжүүлэхийг ЭМДҮЗ-ийн тогтоолоор баталдаг. Тус өөрчлөлтөөс өмнө анхан шатны ЭМБ-аас үзүүлэх 46 нэр төрлийн шинжилгээ болон багажийн оношилгоог ЭМДС-аас санхүүжүүлдэг байсан бол ЭМДҮЗ-ийн 2025 оны 03 тогтоолоор оношилгоо шинжилгээний багцыг 154 нэр төрөл болгож, даруй 108 нэр төрлийн оношилгоо, шинжилгээгээр нэмэгдүүлсэн. Ийнхүү оношилгоо, шинжилгээний төрлийг нэмэгдүүлсэн нь шинээр батлагдсан багцаар анхан шатны ЭМБ-ууд нь халдварт болон халдварт бус өвчнийг хянах, эрт илрүүлэх үүргийг гүйцэтгэхтэй холбоотой бөгөөд эдгээр тусламж, үйлчилгээг үзүүлэхэд шаардагдах холбогдох оношилгоо шинжилгээнүүд тухайлбал иммунологийн шинжилгээ, биохимийн шинжилгээний нарийн үзүүлэлтүүдийг багцад нэмсэн. Энэхүү багцыг өргөжүүлсэн зорилго нь анхан шатны тусламж, үйлчилгээг цогц байлгах бөгөөд үүний үр дүнд лавлагаа шатлалд очиж эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах урсгалыг бууруулах, анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд нь харьяа хүн амаа хянах, эмчлэхэд ач холбогдолтой юм.

- Нэг иргэнээр тооцсон санхүүжилтийг 2024 оноос цахим системд бүрэн нэвтрүүлсэн, мөн урьдчилгаа 80 хувийн санхүүжилтийг олгож үлдэгдэл 20 хувийг гүйцэтгэлийг шалгуурын дагуу үнэлж санхүүжилтийг олгож байна. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад шинэ программ хангамжийг нэвтрүүлж, гүйцэтгэлийг хүний нөлөөгүйгээр бодит цагийн горимоор гүйцэтгэдэг болсон. Нэг иргэнээр тооцсон санхүүжилт 2022 онд 192.3 тэрбум төгрөг байсан бол 2025 онд 416.0 тэрбум төгрөг болж өссөн байна.

8. Одоогийн энэ тогтолцоо нь анхан шатны тусламж, үйлчилгээний чанар, стандартын дагуу иргэдээ өвдсөн хойно нь бус, өвдөхөөс нь өмнө нь урьдчилан сэргийлж, эмнэлгийн тусламж, үйлчилгээг хүртээмжтэй үзүүлэх, шатлал хоорондын шилжилт, давхардлын асуудлыг шийдвэрлэж байгаа эсэх талаар;

- Эрүүл мэндийн салбарын үр ашиг, үр дүнг сайжруулах, эрүүл мэндийн даатгалын санд үүсээд буй нөхцөл байдлыг арилгах, дахин хүндрэл үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/388 тоот тушаал батлагдсан. Уг тушаалын дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлэн ажиллаж

- байна. Тухайлбал ямар тусламж, үйлчилгээг хаанаас /төрөлжсөн, аймаг, дүүрэг, анхан шатаас/ авах талаар холбогдох тооцоо, судалгааг хийн ажилллаж байна.
- Урьдчилан сэргийлэх эрт илрүүлэгт 2025 оны 11 сарын байдлаар 31.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгоод байна. 2026 онд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд огт хамрагдаагүй иргэдийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг шинжилгээнд хамруулах замаар эрт илрүүлэг үзлэгийн хамралтыг нэмэгдүүлэх, урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэгийн салангид багцуудыг холбогдох тогтоол журмыг шинэчилж, нэгдсэн цахим мэдээллийн санг үүсгэх, эрт илрүүлэг үзлэгээр илэрсэн өвчлөлийг эмчлэх, байнгын эмчийн хяналтад байлгаж эргэх холбоог бий болгох ажлыг эрчимжүүлнэ. Мөн ураг, нярай, цэцэрлэг, сургуульд суурилсан, оюутан, цэрэг, зорилтот насанд хийх халдварт бус болон халдварт өвчин, зорилтот бүлэгт хийх зонхилон тохиолдох хорт хавдар, ахмад гэсэн нийт 9 төрлийн эрт илрүүлгээс бүрдсэн багцуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.
9. 2025 оны 10 дугаар сарын байдлаарх эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын хувь, иргэдийг бүрэн хамруулах талаар авч байгаа арга хэмжээ;
- Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн холбогдох заалтын хэрэгжилтийг хангах, хамрах хүрээг өргөтгөх, сангийн орлогын бүрдүүлэлтийг сайжруулах зорилгоор төрийн байгууллагуудтай “Хамтран ажиллах гэрээ”-г байгуулан, гэрээний хэрэгжилтийг ханган ажилласан.
 - Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого хамралтыг нэмэгдүүлэх талаар Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн “2025 оны төсвийн хуваарийг батлах тухай” тогтоол, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын “ЭМД-ын сангийн 2025 оны орлого, хамралтын төлөвлөгөө батлах” А/12 дугаар тушаалыг батлуулан мөрдөж байна. Энэ хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газар болон орон нутгийн эрүүл мэндийн даатгалын хэлтэст хүргүүлж, орлого хамралтын явцад хяналт тавьж хамтран ажиллаж байна.
 - Эрүүл мэндийн даатгалын хамралтыг 11 төрлөөр нэгтгэхэд Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого бүрдүүлэлт 2025 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар 3,268.6 мянган даатгуулагч хамрагдаж, хамрагдалт 93.3 хувьтай байна. Үүнээс төсөвт байгууллага болон ААН байгууллагын 790.2 мянган ажилтан, 36.3 мянган малчин иргэн, 90.4 мянган хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, 54.8 мянган их, дээд сургууль болон мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвд суралцагч, 2,295.9 мянган төрөөс хариуцдаг иргэн, 0.8 мянган гадаадын иргэн хамрагдсан байна.
 - Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын орон нутгийн эрүүл мэндийн даатгалын хэлтсүүдэд орлого хамралтын сар бүрийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг даатгуулагчийн төрлөөр, аймаг, сумаар нь нарийвчлан гаргаж эргэн мэдээлэх тогтолцоог бүрдүүлж ажилласан. Мөн малчдын эрүүл мэндийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн Засаг дарга нартай Эрүүл мэндийн сайдын байгуулах бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээнд тусгайлан заалт оруулж ажилласан. Оюутан, сурагчдын эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлтийн асуудлаар Боловсролын яамтай хамтран ажиллаж байна.
10. Хөнгөлөлттэй эмийн нэр төрөл, хүртээмжийг нэмэгдүүлэхэд зарцуулсан 137.0 тэрбум төгрөгийн зарцуулалт, тавигдсан шаардлагын талаарх мэдээлэл;
- 2025 оны 01-нээс 11 дүгээр сард улсын хэмжээнд нийт 1,537 эмийн сангийн 3,565,056 тохиолдолд 137.0 тэрбум төгрөгийн нэхэмжлэл, төр даах эмийн хөнгөлөлтөд 45 эрүүл мэндийн байгууллагын 114,564 тохиолдлын 52.6 тэрбум төгрөгийн нэхэмжлэл хүлээн авч 149.5 тэрбум төгрөгийн эмийн үнийн хөнгөлөлтийг даатгалын сангаас санхүүжүүлсэн бөгөөд хүний тоо, эмийн сангийн хүртээмж жил бүр нэмэгдэж байна.

- ЭМДҮЗ-ийн 2022 оны 11 дүгээр тогтоол, 2024 оны 06 дугаар тогтоол, 2025 оны 11-р тогтоолууд болон ЭМДЕГ-ын даргын 2024 оны А/171, 2025 оны А/19 дүгээр тушаалын дагуу Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх зайлшгүй шаардлагатай 608 нэр төрлийн эм болон төрөөс төлбөрийг нь хариуцах тусламж үйлчилгээний 114 нэр төрлийн эм нийт 722 нэр төрлийн эмийг ЭМДС-аас олгож байна.
 - Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн дагуу Эрүүл мэндийн даатгалын сангаас эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх эмийн жагсаалтыг боловсруулах, үнийн дээд хязгаар, хөнгөлөлтийн хувийг тооцох аргачлалыг агентлагийн даргын 2024 оны А/137 дугаараар шинэчлэн батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. ЭМД-ын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээг баталсан ЭМДҮЗ-ийн 2022 оны 11 дүгээр тогтоолыг шинэчлэх ажлын хүрээнд эмийн нэр төрлийг оновчтой болгох, батлагдсан төсвийг үр ашигтай зарцуулахаар төлөвлөж байна.
 - ЭМДЕГ-ын даргын 2025 оны А/105 дугаар тушаалаар “Даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх үйлчилгээг худалдан авах гэрээ байгуулах хүсэлт илгээхэд бүрдүүлэх материал, тавигдах шалгуур”-ыг баталсан бөгөөд эмийн нэхэмжлэлийг бүрэн цахимаар хүлээн авч, тоо ширхэг зөв эсэх, эмийн бар код зөв эсэх, үнийн дүн зөв эсэх, иргэний регистрийн дугаар таарч буй эсэх, жорын хүчинтэй хугацаа дууссан эсэх, таблет ID дугаар зөв эсэх гэх мэт шалгуураар цахим хяналт тавин ажиллаж байна.
11. Эрүүл мэндийн даатгалаар санхүүжих анхан шатны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц шинэчлэгдсэн эсэх, шатлал тус бүрд тавигдах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, стандарт, хэрэгжүүлэх бодлого, төлөвлөгөө боловсруулах ажлын явцын талаар;
- Анхан шатны эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх нэг иргэнээр тооцсон тарифыг насны бүлэгтэй нь уялдуулан шинэчлэн боловсруулан, анхан шатны тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, 2022 оноос хойш нэмэгдүүлээгүй суурь тарифт өөрчлөлт оруулах бодлогыг нарийвчлан тодорхойлох, “Хаалга баригч”-ийн үүргийг нь биелүүлэхэд дэмжлэгт орчин бүрдүүлэх зэрэг бодлогын арга хэмжээний өөрчлөлтийг хийхээр төлөвлөж байна.
 - Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/388, А/143 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгүүд анхан шатны эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээний чанар, стандартыг шинэчлэхээр ДЭМБ-тай хамтарч одоогийн мөрдөгдөж буй стандартын хэрэгжилтэд үнэлгээг хийн, шинэчлэх стандартын төслийг боловсруулан ажиллаж байна.
12. Улсын эмнэлгийн зайлшгүй шаардлагатай шинэчлэх тоног төхөөрөмжийн шинэчлэлт, олон улсын төсөл, хөтөлбөр хэрэгжсэн үр дүнгийн талаарх мэдээлэл;
- Монгол Улсын 24.6 тэрбум төгрөг, гадаадын зээл тусламжын санхүүжилтийн хүрээнд “Хавдрын урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийн үндэсний сүлжээ байгуулах төсөл”-ийн санхүүжилтээр 14.2 тэрбум төгрөг, Люксембургийн Зүрхний төвтэй хамтран 918.4 сая төгрөг, Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй “Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр” төслийн санхүүжилтээр 14.7 тэрбум төгрөг нийт 54,4 тэрбум төгрөгийн эмнэлгийн тоног төхөөрөмжийг 2025 онд эрүүл мэндийн байгууллагуудад олгоод байна.
 - Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмжийн шинэчлэлд зориулж 340.2 тэрбум төгрөгийн төсвийн тооцооллын саналыг хүргүүлсэн ба 60.7 тэрбум төгрөг батлагдаад байна.

13. Хувийн эмнэлгүүдийн үйлчилгээний чанарын хяналт хэрхэн хийгддэг, хувийн эмнэлэгтэй харьцуулахад улсын эмнэлгүүдийн оношилгоо, эмчилгээний чанарт ялгаа байгаа эсэх;

- Тусламж, үйлчилгээний чанар, төлбөрийн хяналт хийхдээ эрүүл мэндийн байгууллагын өмчийн хэлбэрээс үл шалтгаалан ижил шалгуураар үнэлдэг мөн иргэн эрүүл мэндийн байгууллагаа сонгон үйлчлүүлэх боломжийг хуулиар зохицуулсан ба аль ч байгууллагад хийлгэсэн оношилгоо шинжилгээний дүгнэлтийг эмчилгээ, үйлчилгээнд ашиглах боломжтой юм.

№	Эх үүсвэр	Санхүүжилтийн мөнгөн дүн (тэрбум төгрөг)				Үүнээс: ЭМД сан, сангаар дамжсан	Санхүүжилтийн мөнгөн дүн (тэрбум төгрөг)			
		2020 он		2021 он			2022 он		2021 он	
		2020 он	2022 он	Нийт	2020 он		2022 он	2020 он	2022 он	
1	Улсын төсөв	68.8	148.8	284.0	501.6	319	0	35	284	46.9
2	Засгийн газрын нэмэлт санхүүжилт	12.2	65.9		78.1	34	0	34		5.0
3	Бусад улсын төсвийн нэмэлт санхүүжилт	0.5			0.5	0				-
4	Эрүүл мэндийн даатгалын сангаас		295.1	27.8	322.9	322.9		295.1	27.8	47.5
5	Олон улсын байгууллага зээл тусламж	62.9	427.7		490.6	0				-
6	Иргэдийн хандив тусламж	0.4	0.0		0.4	0				-
7	Аж ахуй нэгжийн хандив тусламж	8.8	38.9		47.7	4.5		4.5		0.7
Нийт дүн		153.5	976.4	311.8	1,441.7	680.4	-	368.6	311.8	100

№	Зардлын нийт зарцуулалт (зардлын ангилалаар)	Зарцуулалтын мөнгөн дүн (тэрбум төгрөг)				Үүнээс: Улсын төсвөөс	Санхүүжилтийн мөнгөн дүн (тэрбум төгрөг)			
		2020 он	2021 он	2022 он	Нийт		2020 он	2021 он	2022 он	Эзлэх хувь
1	Илүү цагийн хөлс	11.8	6.2		18.0	56.2	10.1	46.1	11.21	
2	Урамшуулал цалин	3.6	48.4		52.0	-			-	
3	Урвалж оношлуур	17.8	46.3		64.1	58.8	25.1	33.7	11.72	
4	Эм, эмнэлгийн хэрэгсэл	18.8	32.3		51.1	-			-	
5	Вакцин биобэлдмэл		367.1		367.1	-			-	
6	Хамгаалах хувцас хэрэгсэл	37.5	26.8		64.3	48.0	33.5	14.5	9.56	
7	Бараа материал	0.7	1.4		2.1	-			-	
8	Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ	1.7	6.4		8.1	5.0		5.0	0.99	
9	Эмнэлгийн тусламж, үйлчилгээ		73.5	606.9	680.4	319.0		35.0	63.59	
10	Тоног төхөөрөмж	54.9	67.0		121.9	14.7		14.7	2.92	
11	Барилга байгууламж	6.7	5.9		12.6	-			-	
Нийт дүн		153.5	681.3	606.9	1,441.7	501.6	68.8	148.8	284.0	100

№	ЭМД сангаар дамжсан зардлын зарцуулалт (зардлын ангилалаар)	Санхүүжилтийн мөнгөн дүн (тэрбум төгрөг)			
		2020 он		2021 он	
		2020 он	2021 он	2022 он	Нийт
1	Дархлаажуулалтын үйл ажиллагаа	22.2	4.9		27.1
2	Өрхийн гэрийн хяналт	44.6	50.4		95.0
3	ПГУ сорил цуглуулах	1.1	2.9		4.0
4	PCR шинжилгээ	15.2	29.2		44.4
5	Хэвтэн эмчлүүлэх	285.5	224.4		509.9
Нийт дүн		368.6	311.8		680.4

№	Төрөл	2021 он гүйцэтгэл		2022 он гүйцэтгэл		2023 оны гүйцэтгэл	
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн
	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ		420,000		420,000		550,000
1.	0-18 насны хүүхэд;	1,186,573	63,625	1,312,073	66,128	1,329,131	107,037
2.	тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй иргэн;	581,623	7,249	561,008	56,550	538,558	86,741
3.	хүүхдээ 2 /ихэр бол 3 / нас хүртэл нь өсгөн бойжуулж байгаа эх /эцэг/;	81,821	7,188	97,033	9,781	86,357	13,909
4.	Нийгмийн халамжийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан иргэн;	439,412	4,787	298,599	30,099	263,645	42,463
5.	хугацаат цэргийн жинхэнэ албан хаагч;	9,418	690	6,809	686	6,021	1,097
6.	Ял эдэлж байгаа ялтан	4,997	201	4,581	462	5,055	814
	НИЙТ	2,303,844	83,739	2,280,103	163,705.9	2,228,767.0	252,060.1

№	Төрөл	2024 оны гүйцэтгэл		2025 оны төсөв		2026 оны төсвийн төсөл		
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн (2 хувь)	Мөнгөн дүн (3 хувь)
	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ		660,000		792,000			792,000
1.	0-18 насны хүүхэд;	1,353,649	137,702	1,329,131	210,534.4	1,353,649	257,301.6	385,952.4
2.	тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй иргэн;	554,674	111,593	538,558	85,307.6	554,674	105,432.4	158,148.7
3.	хүүхдээ 2 /ихэр бол 3 / нас хүртэл нь өсгөн бойжуулж байгаа эх /эцэг/;	97,922	17,894	86,357	13,678.9	97,922	18,613.0	27,919.5
4.	Нийгмийн халамжийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан иргэн;	274,849	54,629	263,645	41,761.4	274,849	52,243.3	78,364.9
5.	хугацаат цэргийн жинхэнэ албан хаагч;	5,208	1,248	6,021	953.7	5,208	989.9	1,484.9
6.	Ял эдэлж байгаа ялтан	4,908	1,047	5,055	800.7	4,908	932.9	1,399.4
	НИЙТ	2,291,210.0	324,113.0	2,228,767.0	353,036.7	2,291,210.0	435,513.2	653,269.8
					2026 оны батлагдсан төсөв	431,181,291.9		217,756.6